

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Даваасүрэн	Дугаар	L274
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Тариалан сум
Төрсөн газар	Тариалан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гөрөөчний хүрээ, Давааны арын дуган	Сүм хийдийн дугаар	ХӨТР 057, ХӨТР 060
Одоогийн сүм хийд	Гандандашлин хийд	Сүм хийдийн дугаар	ХӨТР 015
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Тариалан сумын Гөрөөчний хүрээ, Давааны арын дуган

Мөнхбат: За энэ Гөрөөчний хүрээ маань тухайн үедээ Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны хойд нутаг хязгаарыг голлосон.Тухайн үеийн бурхан шашны томоохон төв болж байсан нь энэ хүрээний түүх, за энэ хүрээний туурь, туурин дээр үлдсэн шашны сүм дацан дуганы одоо барилга байгууламжийн туурь зэргээс харагдаж байна. Тэгэхээр өнөөдөр энэ Гөрөөчний хүрээний тухай энэ гөрөөчний хүрээний үүсэл хөгжлийн тухай мөхлийн тухай одоо дараах ярилцлагыг хийсэн юм аа.Ингээд бид нар энэ удаагийнхаа ярилцлагыг Тариалан сумын хийдийн лам Даваасүрэнтэй одоо уулзаж ярилцсан юм аа. За тэгэхээр хоёулаа ярилцлагаа эндээс эхлэе. Энэ Гөрөөчний хүрээний тухай ярихаас өмнө энэ Гөрөөчний гэсэн нэрийн тухай яривал яасан юм. Яагаад энэ Гөрөөчний гэж нэрлэж байсан юм бол, энэ миний бодлоор энэ газар усны нэр биш бололтой одоо бодогдож байна?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Даваасүрэн: Гөрөөчин овог бол эрт дээр Өвөрхангайгаас гаралтай. Тэнд одоо өөрөөр хэлвэл энэ шинэ цагийн юу гэхчээр тэнд хавчигдаж гадуурхагдаж үзэл бодол нийлээгүй долоон хүмүүс оргож босч энэ Элэнхэйн битүү гэдэгт амьдарч суурьшиж энэ долоон гөрөөчний овог одоо үүссэн юм гэсэн.

Мөнхбат: Тэгэхээр одоо энд одоо эрт дээр үеэс суурьшсан тэр гөрөөчин хэмээх хүмүүсийн үр удам, гөрөөчний гэдэг овогтой болсон тэр цаг үеэс л одоо энэ хүрээ хийдийн нэр холбоотой болж таарч байна, тийм ээ. Тэгэхээр одоо энэ Гөрөөчний хүрээний анх шав тавьсан тэр цаг үе түүхийг та одоо сонссон мэдсэнээ хуучлахгүй юу?

Даваасүрэн: Аа тэр үеийн хууччуул хөгшчүүл ярьж байгаа нь 1777 онд анх энэ Гөрөөчний хүрээ үүссэн гэж ярьдаг юм.

Мөнхбат: За одоо энэ Гөрөөчний хүрээний газрын байршил одоо сумын төвөөс хойшоо арван найман км-т байх энэ урдаа модтой бас ийм булагтай нар мандах нар жаргах нь одоо байнга үзэгдэж харагдах ийм харууц сайта ийм сайхан цэвэрхэн дэвсгэр дэнж дээр баригдсан байх юм. Тэгэхээр энэ урд уул ямар уул гэлээ?

Даваасүрэн: Тавхар уул.

Мөнхбат: Тавхар уул гэсэн. За хойд талд бол ийм Сантын овоо гэж байна. Нутгийн тахилгатай ийм овооны бэл тэр Сантын дэвсгэрт энэ хүрээ байрлаж байна. Тэгэхээр энэ хүрээний ид шашин номынхоо мандан бадралын үед хэдэн ламтай байсан юм, ямар ямар ном голлож хурдаг байсан юм, за шашны одоо ямар зан үйл хийж байсан тухай?

Даваасүрэн: Аа тухайн үедээ Гөрөөчний хүрээ долоон дугантай, таван зуу гаруй лам шавилан суудаг байсан гэсэн. Аа тэгээд намар болохоор майдар эргэж, цам майдраа эргэж бүждэг байсан юм гэсэн.

Мөнхбат: Энэ Гөрөөчний хүрээний одоо шүтээн онгон сахиус нь юу байсан юм бол?

Даваасүрэн: Махгал Гомбо гэж бурхан шүтээн.

Мөнхбат: Гөрөөчний хүрээнд тахигдаж байсан бурхан тахил, за уншигдаж хуралд ашиглагдаж байсан ном судруудаас өнөөгийн шинэ цагийн одоо танай хийдэд өвлөгдөж ирсэн тийм одоо өв эдээс юу юу байна?

Даваасүрэн: Аа энэ их бага хоёр бүрээ гэж сунадаг, гурван метр хоёр бүрээ. Аа мөн Түшээт хан Гомбодорж ханы есөн эрдэнэ сулгаж шигтгэж өгсөн энэ жанрайсиг бурхан зэрэг бүрээ бишгүүр цан хэнгэрэг юм бий.

Мөнхбат: За одоо хоёулаа энэ хүрээнийхээ байгууламж руу эргээд орёе. Тэгэхээр одоо бид нарт ингэж харагдаж байгаа энэ хүрээний туурийг харахад үнэхээр долоон найман дуганы туурь, за одоо мөн жасын модон, жас хүрж байсан модон дуганы суурь. За энэ цогчин дуганыхаа дөрвөн талд босгосон том суварганы сууриуд, за мөн хоёр ч том хүрдний суурь. За мөн цогчин дуганаасаа урагшаа нэг гучаад метр газарт байх 25-30 метрийн газарт байх 10-12 метрийн өндөртэй болов уу гэж таамаглаж байна. Өндөр маани гэж нэрлэгддэг энэ том хоёр багана. За тэр мөн одоо энэ хүрээний гол дугануудын байршлын тэгийн хилийн дөрвөн талд байх өндрөөрөө нэг ная орчим см өндөртэй. Өргөнөөрөө нэг 50-60 см өргөн ийм хавтгай боржин чулуун дээр бичсэн маанийн үсэгнүүд бүхий ийм одоо дурсгал байх юм. За мөн энэ Гөрөөчний хүрээ өмнө буюу одоо яг тэр цогчин дуганы өмнөд талд тухайн үеийн одоогоос нэг хоёр зуу гаруй жилийн тэртээ хийгдэж бүтээгдсэн энэ хүрээний хамгийн том суварга болох энэ суварганы суурь байна. За энэ суурин дээр 1990-ээдл оноос хойш нутгийн

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

сүсэгтэн олнууд бас энэ суваргыг анхны хэв загвараар нь бүтээх гэж оролдож тэр нурж унасан үе давхар өрлөгүүдийг тоосгоор хийж эхэлсэн бололтой. Гэвч энэ суварга бол одоо хараахан бүтээгдээгүй. Ингээд ажил нь дундуураа орхигдсон юм байна. За мөн 1937, 1938 оны үед энэ Гөрөөчний хүрээг мөхөхөөс өмнөхөн талд одоо баригдаж авсан тэр энд сууж байсан лам хувраг шашны мяндагтнуудыг одоо барьж цаазалсан байдаг. Тэгэхээр энэний цаазалсан хүмүүсийн үр хүүхэд хойч үеийнхэн нь 1990-ээд оны одоо ардчиллын үр шимээр өвөг дээдэс нь цагаатгагдаж. Тэгээд тэр цагаатгагдсан лам нарын хүүхдүүд хойч үе өвөг дээдсийнхээ гэгээн дурсгалыг хүндэтгэж хоёр ч суварга босгосон юм байна. За энэний нэг суварга нь бол одоо тэр яг Лувсан... хэн гэж байлаа, тэр гавж?

Даваасүрэн: Моломжамц.

Мөнхбат: Тийм, гавж Моломжамц гэдэг хүний хүүхдүүдээс босгосон суварга энэ гөрөөчний түүрийн хойд талд байна. За мөн баруун талд нь болохоор зэрэг зүгээр сумын сүсэгтэн олны ивээл хандив тусламжаар боссон бас одоо хэлмэгдэгсдийнхээ дурсгалыг хүндэтгэж зориулж босгосон ийм суварга байна аа.

Давааны арын дуган

Мөнхбат :За манай судалгааны баг энэ Хөвсгөл аймгийн Тариалан сумын төвөөс зүүн хойш тус сумын Давааны ар багийн нутагт байх, сумын төвөөс жараад км-ийн зайтай оршдог энэ газарт академич Ренчин гуайн жагсаалтанд ороогүй ийм нэг хоёр Давааны арын дуган гэсэн ийм хоёр дацангийн судалгааг хийж байна. Тэгэхээр бид нар Тариалан сумын төв дээр ирээд Тариалан сумын хийдийн хамба лам Даваасүрэн гуайтай уулзаж ярилцахад Ренчин гуайн жагсаалтанд байсан Зүлэгтийн хурал гэж газрын тухай лавлахад за Зүлэгтийн хурал гэж газар энд ерөөсөө байгаагүй. Аа Зүлэгтийн гол гэдэг нэртэй газар бол бий. Харин Зүлэгтийн хурал гэдэг нэртэй газар бол манай суманд ерөөсөө байгаагүй ээ. Аа тэр Зүлэгтийн гол бол сумын төвөөс урагшаа арван нэгэн км-ын зайтай байдаг. Энэ газар бол тийм юм байгаагүй. Ер нь бол манай сумын түүхэнд ч байхгүй, өвөг дээдсийн амнаас ч одоо ийм юм сонсож дуулаагүй гэсэн ийм одоо яриа өрнөсөн юм, бидний дунд. Харин энэ жагсаалтад ороогүй боловч манай сумын нутагт байдаг тэр Давааны ар гэдэг газар байдаг хоёр дуган бол бий гэсэн тухай бидэнд энэ мэдээллийг өгсөн, хоёр дуганы туурь. Тэгээд энэ хоёр дуганыг ингээд хэмжиж судалж мөшгиж үзвэл сумын төвөөс жараад км зайтай энэ Давааны ар гэдэг газар байдаг юм байна. За энэ газарт байсан энэ хоёр дуган бол бага хэмжээний хоёр дуган. За түр цагийн хуралтай, эндээс одоо тавь шахуу км зайтай байх энэ бүс нутгийн шашин номын томоохон төв болсон Гөрөөчний хүрээний салбар дуган. Гөрөөчний хүрээнээс одоо намар хавартаа лам нар гарч ирж ном уншдаг. За мөн жил сар бүрийн онцгой өдрүүдэд лам нар ээлжлэн ирж ном уншиж энэ хавийн сүсэгтэн олондоо үйлчилдэг байсан гэж ийм мэдээллийг энэ хамба лам Даваасүрэн бидэнд ярьж байна. За бид энд зураг авч баримтжуулах гэсэн боловч цаг агаарын энэ таагүй байдлаас болоод хийж чадаагүй. Зургийг бол авч чадаагүй. Гэвч одоо хэдийгээр хоёрхон ширхэг

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

жигжиг дуган байгаа ч гэсэн энэ бол одоо энэ сумын нутагт байдаг Ренчин гуайн жагсаалтад бичигдээгүй ийм хоёр дуганы түүрх байгаад бид бас тодорхой хэмжээгээр олзуурхсан юм аа.Тэгэхээр Даваасүрэн гуай яг сая миний ярьсан энэ дуганы талаарх мэдээлэл одоо таны өгсөн мэдээллийг би энэ дуу хураагуурт бичлээ.Тэгэхээр одоо энэ дээр нэмж хэлэх юм байна уу, таны одоо яг мэдэж байгаа мэдээлэл энэ байна уу?

Даваасүрэн: Өө яг л энэ юу ярьснаараа л байна.

Мөнхбат: Гөрөөчний хүрээний л салбар байсан?

Даваасүрэн: Аа нэг салбар хурал л хурдаг одоо дацан байсан юм билээ.

Мөнхбат: За баярлалаа, таньд.